



**“МӨРӨӨДЛИЙН ТЭЭВЭР-2050” СЭДЭВТ ЭСЭЭ,
ГАР ЗУРГИЙН ХҮҮХДИЙН БҮТЭЭЛИЙН
УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

2021.11.04

Улаанбаатар хот

2022 оныг угтан “Шинэ жилийн баяр”-ыг тохиолдуулан хүүхдүүдийн дунд “Мөрөөдлийн тээвэр-2050” сэдэвт бүтээлийн уралдааныг зарлаж байна.

Уралдааны зорилго: Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд багачуудын дотоод ертөнц, тэдний нүдээр зам, тээврийн салбарыг харах, хүсэл мөрөөдлийг сонсох, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй бүтээлч байдлаар илэрхийлэхийг дэмжихэд оршино.

Уралдааны хугацаа: Уралдааны материалыг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн 17:00 цаг Зам, тээврийн хөгжлийн яамны 107 тоотод хүлээн авч, 12 дугаар сарын 15-ны өдөр шалгаруулна.

Хамрах хүрээ, сэдэв: Уралдаанд 4-18 насны хүүхэд багачуудыг хамруулах бөгөөд Хүүхдүүд ирээдүйд тээврийн салбараас юу хүсэх вэ, ирээдүйн эздэд бид ямар нийгмийг хүлээлгэж өгөх вэ зэрэг санааг дэвшүүлсэн гар зураг, зохион бичлэг/эсээ/ гэсэн төрлүүдээр хүүхэд бүр өөрийн үзэл бодол, хүсэл мөрөөдлөө төсөөлөн чөлөөт бүтээл ирүүлж болно.

Насны ангилал: Уралдааныг цэцэрлэгийн нас, 1-5 анги, 6-9 анги, 10-12 анги гэсэн ангиллаар зохион байгуулна.

Оролцох хэлбэр:

1. 4-6 нас буюу цэцэрлэгийн нас /гар зураг/
2. 1-5 анги /гар зураг, зохион бичлэг/эсээ/
3. 6-9 анги, 10-12 анги /зохион бичлэг /эсээ//

Хүүхдийн бүтээлд тавигдах шаардлага:

А.Гар зураг

- Гар зургийн бүх төрлөөр А3 формат /42x29,7 см/ дээр усан будаг, гуаш, өнгийн харандаа, фламастер зэрэг зургийн бүх хэрэгсэл, материалыг ашиглаж зурна.

- Уралдаанд оролцох бүтээл нь хүүхдийн уран сэтгэмжээр зурагдсан байх бөгөөд ном, сэтгүүл, сурах бичгээс хуулбарласан буюу бусдын тусламжаар зурсан зургийг уралдаанд оролцуулах боломжгүй.

- Зургийн ар талд овог нэрийг бүтнээр, бүтээлийн нэр, нас, хүйс, хот, дүүрэг, сургууль анги болон харилцах утасны дугаарыг бичнэ. Мөн зургийн баруун доод өнцөгт өөрийн нэр болон бүтээлийг зурж дууссан хугацааг бичнэ.

Б.Зохион бичлэг, шүлэг

- Хүүхдүүд өөрсдийн бичсэн зохион бичлэгээ уншиж Youtube хуудсанд Unlisted хэлбэрээр байршуулж, линкийг uugandulam@mrttd.gov.mn цахим шуудан руу бүтээлийн хамт илгээх ба цаасаар яамны 107 тоотод хүлээн авна.

- Видео бичлэгийн үргэлжлэх хугацаа 2.0 минутаас хэтрэхгүй байна.

Уралдааныг дүгнэх: Гар зургийн бүтээлийг Зам, тээврийн хөгжлийн яамны Фэйсбүүк хуудсанд байршуулж, олонхын саналаар шалгаруулна.

Зохион бичлэгийг /Эсээ/ Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Залуучуудын зөвлөлийн гишүүдээс бүрдсэн бүрэлдэхүүн дэвшүүлсэн шинэ санаа, шийдэл, боломж эрэлхийлсэн эсэхийг үнэлгээ өгч шалгаруулна.

Уралдааныг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр насны ангиллаар дүгнэж ангилал бүрт I, II, III байр эзлүүлнэ.

Шагнал урамшуулал:

- I байр : Өргөмжлөл, тусгай шагнал
- II байр : Өргөмжлөл, тусгай шагнал
- III байр : Өргөмжлөл, тусгай шагнал

Уралдаанд оролцсон бүтээлүүдээр үзэсгэлэн гаргана.

Тодруулга, лавлагаа:

Зам, тээврийн хөгжлийн яамны 107 тоот өрөө. Утас: 89023077, 99131955

---o0o---